



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/156

Улаанбаатар хот

Элсэлтийн журам батлах тухай


Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Босго оноо тогтоох тухай” А/138 дугаар тушаал, ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалт, “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ын 6.1.5 дахь заалт, Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн захирлын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэл, ШУТИС-Коосэн Технологийн коллежийн захирлын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэл, ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022/2023 оны хичээлийн жилд “ШУТИС-Коосэн Технологийн коллежид суралцагч элсүүлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуульд суралцагч элсүүлэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал, Элсэлтийн төв комиссын дарга (Н.Ганзориг)-д даалгасугай.

3. Элсэлтийн төв комисстой хамтран ажиллаж, элсэлтийн үйл ажиллагааг журамд заасны дагуу зохион байгуулахыг ШУТИС-Коосэн Технологийн коллежийн захирал (Д.Болдбаатар), ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирал (Д.Нямсүрэн), Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн захирал (Ц.Батбаатар) нарт даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.НАМНАН

367040809



ШУТИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/156 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН “ШУТИС-КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИД 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 333 дугаар тушаалын хавсралт “Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам” –ын 3.3 дахь заалт, шинжлэх ухаан технологийн их сургуулийн холбогдох журмууд, сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 3 дахь заалтыг тус тус баримтлан “ШУТИС-Коосэн” технологийн коллежид 2022-2023 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 “ШУТИС-Коосэн” технологийн коллежид элсэн суралцахаар хүсэлт гаргагчийн элсэлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.3 Сургуулийн материаллаг бааз, анги кабинетийн хүрэлцээ зэргээс хамааран шинээр элсэх суралцагчдын тоог захирлын зөвлөлийн шийдвэрээр тогтооно.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС БАЙГУУЛАХ

- 2.1 “ШУТИС-Коосэн” технологийн коллежийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүн, гишүүдийн ажил үүргийн хуваарийг “ШУТИС-Коосэн” технологийн коллежийн захирлын тушаалаар батална.
- 2.2 Элсэлтийн комисс нь энэхүү журмыг баримтлан элсэлтийн шалгалтыг зохион байгуулах, элсэгчдийн материалыг шалгах, өргөдөл гомдлыг барагдуулах, элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.

ГУРАВ. ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1 Суурь боловсрол эзэмшсэн байх.
- 3.2 Инженер техник, технологийн /Барилгын инженер, цахилгааны инженер, механик инженер/ чиглэлээр суралцах сонирхолтой байх.

ДӨРӨВ. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДИЙГ БҮРТГЭХ

- 4.1 “ШУТИС-Коосэн” технологийн коллежид орон даяар цахим элсэлтийн бүртгэлийг ШУТИС-ийн элсэлтийн цахим веб хуудас www.elseit.edu.mn-аар хийнэ.
 - 4.1.1. Элсэхийг хүсэгчдийн бүртгэл 2022 оны 05 сарын 16-наас 2022 оны 06 сарын 11-ний 10.00 цагийн хооронд явагдана.
- 4.2 Бүртгэлийн хураамж 15000 төгрөг. Бүртгэлийн хураамж төлөх дансны дугаар /Хаан банк: ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ 5031748624/

ШУТИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/156 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



- 4.3 Бүртгэлийн хураамжийг элсэлтийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулна.

ТАВ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 5.1 Элсэлтийн шалгалт нь
- 5.1.1 Бичгийн шалгалт
 - 5.1.2 Ярилцлага гэсэн хоёр шаттай явагдана.
- 5.2. Элсэлтийн шалгалтын тов.
- 5.2.1. 6 дугаар сарын 11-ний 14.00 цагт ШУТИС-ийн VIII байрны 301 тоот ангид авна.
 - 5.2.2. Нэмэлт элсэлтийн шалгалтыг 8 дугаар сарын 22-ны 10.00 цагт ШУТИС-ийн VIII байрны 301 тоот ангид авна.
- 5.2 Элсэлтийн шалгалт нь математикийн хичээлийн агуулга 70%, физикийн хичээлийн хичээлийн агуулга 30%-ийн бүтэцтэй байна.
- 5.3 Шалгалтын үндсэн зарчим
- Шалгалтын даалгавар, шалгуур түвшинд нь тохирсон, үнэн зөв, суралцагчдад ойлгомжтой, бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх болон тэдний сэтгэн бодох чадварыг нээн илрүүлэх боломжтой байх
 - Шалгалт шударга, ил тод байх
 - Шалгалтын сэдэв боловсруулах багийг томилох, нууцлалыг хадгалан ажиллах үүргийг шалгалтын комисс хариуцна.
- 5.4 Шалгуулагчдыг онооны дарааллаар жагсаан сургуулийн веб сайт болон мэдээллийн самбарт байрлуулна.
- 5.5 Элсэлтийн шалгалтад 70%-иас дээш дүгнэгдсэн тохиолдолд эхний шатанд тэнцсэн тооцон, ярилцлагын шалгалтад оруулна. Ярилцлагын товыг сургуулийн веб сайт болон мэдээллийн самбарт зарлана.
- 5.6 Ярилцлагад 70%-иас дээш дүгнэгдсэн тохиолдолд “ШУТИС-Коосэн” технологийн коллежийн элсэлтийн шалгалтад тэнцсэнд тооцно.

ЗУРГАА. СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ

- 6.1 “ШУТИС-Коосэн” технологийн коллежоос зохион байгуулсан элсэлтийн шалгалтын босго оноог үндэслэн суралцагчийг элсүүлнэ.
- 6.2 Элсэгч нь математик, физик, дүрслэх урлаг, дизайн технологи, мэдээллийн технологи хичээлүүдээр улс, нийслэлийн хэмжээний олимпиадад 1-5-р байр, бүс, улс, олон улсын хэмжээний чанартай олимпиад, уралдаан тэмцээнд 1-10-р байр эзэлсэн бол гэрчлэх баримтыг үндэслэн шалгалтгүй элсүүлнэ.
- 6.3 Элсэлттэй холбоотой аливаа маргааныг элсэлтийн комисс эцэслэн шийдвэрлэнэ.

ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

- 7.1 Элсэлтийн комиссын шийдвэрээр шалгалтад тэнцсэн элсэгчдийг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 30-ны хооронд



ШУТИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/156 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ШУТИС-ийн VIII дугаар байрны 302 тоотод бүртгэнэ. Элсэгч нь бүртгүүлэхээр ирэхдээ доорх материалыг бүрдүүлэн, асран хамгаалагчийн хамт ирнэ. Үүнд:

- Сурагчийн хувийн хэрэг (шилжүүлэг хийлгэсэн байх)
- Суурь боловсролын гэрчилгээ
- Төрсний гэрчилгээний баталгаажуулсан хуулбар
- Эцэг эх, асран хамгаалагчийн иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар
- 2 хувь цээж зураг /сүүлийн 6 сарын/
- Сургалтын төлбөр төлсөн баримт

7.2 2022-2023 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг төлсний дараа “ШУТИС-Коосэн” технологийн коллежид суралцах эрхийн бичиг, оюутны код, үнэмлэх олгож, суралцах гэрээ байгуулна.

7.3 Элсэгчид эрүүл мэндийн үзлэгт орж, эрүүл мэндийн хуудас нээлгэнэ.

7.4 Суралцах эрх авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчдийг элсэхээс татгалзсан гэж үзэн элсэх эрхийг хүчингүйд тооцно.

7.5 Сурагчийн хувийн хэрэг болон, суурь боловсролын гэрчилгээний зөрчилтэй суралцагчдыг элсүүлэхгүй болно.

НАЙМ. НЭМЭЛТ ЭЛСЭЛТ

8.1 Нэмэлт элсэлтийн шалгалтыг 8 сарын сарын 22-ны 10.00 цагт ШУТИС-ийн VIII байрны 301 тоот ангид авна.

8.2 Хичээлийн жилийн хаврын улиралд анги дүүргэлтийг нөхөж, энэхүү журамд заасан шаардлагыг хангасан суралцагчийг нэгдүгээр ангид шилжүүлэн авч суралцуулж болно.

--- оОо ---